



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Огноо: Пүрэв гараг, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр
Хаана: Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхим

Хувьцаа эзэмшигчид:	
Голомт Файнэншл Групп ХХК	77.20%
Свисс-МО Инвестмент АЖ	5.21%
Голомт Инвестмэнд Лимитэд	2.57%
Бодь Интернэйшнл ХХК	3.42%
Олон нийт	11.60%
Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдээлэл танилцуулахаар хуралд оролцогчид:	
Гүйцэтгэх захирал	А.Одонбаатар
ТУЗ-ийн гишүүн	Д.Мөнхтөр
Ерөнхийлөгч	Г.Ганболд
Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал	Г.Соёлмаа
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	З.Солонго
Дотоод аудитын газрын захирал	А.Туяа
Тооллогын комисс:	
Ерөнхий аудитын хэлтсийн захирал	Б.Хишигжаргал (Дарга)
Удирдлагын мэдээллийн хэлтсийн захирал	Н.Саруулчимэг (Гишүүн)
Үйлдвэр худалдааны хэлтсийн захирал	Б.Золбоо (Гишүүн)
Хуулийн хэлтсийн хуульч	Б.Мөнхбаяр (Гишүүн)
Стратеги хамтын ажиллагааны хэлтсийн захирал	Б.Хосбаяр (Гишүүн)
ТУЗ-ийн ажлын алба, Хөрөнгө оруулалтын менежер	Э.Тэлмэн (Нарийн бичиг)
Хурал 09:20 цагт эхлэв.	
Голомт Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын танхимд болон golomtbank.com веб хуудсаар шууд дамжуулж, танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдав. Хуралд Голомт Банк ХК-ийн ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд оролцов. Хурлыг жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон Голомт банкны Ерөнхийлөгч Г.Ганболд даргалж, хурлыг 09:20 минутад албан ёсоор нээв. Хурлын дарга Г.Ганболд: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж байгаа учраас хурлыг албан ёсоор нээе. Монгол улсын Компанийн тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу нээлттэй хувьцаат компани жилдээ санхүүгийн жил өнгөрсний дараа 4 сард багтаан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийдэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал бол нээлттэй компанийн эрх барих дээд байгууллага. Та бүхний мэдэж байгаачлан 2022 оны эцсээс эхлэн монголын хөрөнгийн зах зээлд том хувь нэмэр болсон үйл явдал болсон нь системийн ач холбогдол бүхий таван банк нээлттэй компани болж, олон нийтэд анх удаа хувьцаагаа арилжсан. Ингэснээр Голомт банк 21 мянга орчим шинэ хөрөнгө оруулагч буюу хувьцаа эзэмшигчтэй болсон. Энэ хугацаанаас хойш 2022, 2023 оны ажлын үр дүн гээд нэг ээлжит бус хурлыг оруулвал нийт дөрвөн удаа Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулсан. Энэ хуралд идэвхтэй оролцдог хувьцаа эзэмшигч нар маань хүрэлцэн ирсэнд талархлаа илэрхийлье. Бид энэ олон мянган хувьцаа эзэмшигчдийг бүгдийг нь нэг дор цуглуулаад биет хурал хийх боломжгүй тул сүүлийн үеийн практикаар онлайн болон биет хосолсон хэлбэрээр хурлаа зохион байгуулж байна. Энэ танхимд 300 орчим хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн байна. Бусад нь онлайн байдлаар шууд дамжуулж байгаа цацалтыг үзээд хуралд оролцон саналаа өгөх боломжтой байна. Голомт банкны хувьцаа эзэмшлийн 85 орчим хувийг Голомт санхүүгийн нэгдэл болон Бодь интернэйшнл ХХК, бусад нь олон нийт болон гадны хөрөнгө оруулагчид гэсэн бүтэцтэй байгаа.	



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 03 дугаар сарын 07-нд хуралдаад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4-р сарын 17-ны өдөр буюу өнөөдөр энэ танхимд хийх шийдвэрийг гарган Тооллогын комисс болон зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батласан. Түүний дагуу ажлын хэсгүүд ажлаад ийнхүү өнөөдрийн хурлаа эхлүүлж байна. Хурлаар хэлэлцүүлэх асуудал бол хуульд заасны дагуу нийт 9 асуудал байгаа. Гол агуулга нь өнгөрсөн 2024 оны Голомт банкны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулна. Ийнхүү хурлыг албан ёсоор нээсэн тул хурлын ирцийг танилцуулна уу хэмээн Ерөнхий аудитын хэлтсийн захирал Тооллогын комиссын дарга Б.Хишигжаргалыг урьж байна.

Тооллогын комиссын дарга Б.Хишигжаргал: Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Тооллогын комиссын зүгээс хувьцаа эзэмшигчдийн хурлын албан ёсны ирцийн мэдээллийг танилцуулъя. Өнөөдрийн хуралд энэ цаг мөчид 717,803,100 хувьцаа эзэмшдэг хөрөнгө оруулагч нар хуралд оролцсоноор бүртгүүлснээр хурлын ирц маань 88,73 хувьд хүрсэн буюу Компанийн тухай хуулийн 69.1-дэх хэсэгт заасны дагуу хурлыг хүчин төгөлдөр хуралд тооцсугай.

Тооллогын комиссын дарга хурлын системд нэвтрэх, хуралд санал өгөх зааврыг дэлгэрэнгүй танилцуулав.

Хурлын дарга Г.Ганболд: Б.Хишигжаргал захиралд баярлалаа. Компанийн тухай хуульд заасны дагуу хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ-ийн тогтоолоор баталсан. Өнөөдрийн хурлаар дараах есөн асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Голомт банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Голомт банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах;
3. Голомт банк ХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт;
4. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
5. 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2025 оны цалингийн төсөв;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
7. Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхэгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай;
8. Банкны дүрэм өөрчлөн батлах тухай.
9. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай;

Хурлын дэгийг танилцуулав:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заасан эрх бүхий албан тушаалтан хурлыг удирдан явуулна.
- Хурлын ирцийг Тооллогын комисс танилцуулснаар Хурлын дарга албан ёсоор хурлыг нээнэ.
- Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэхгүй.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу явуулна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг мэргэжлийн хөндлөнгийн компаниар бичлэг хийлгэж цахим хэлбэрээр шууд дамжуулалт хийх ба энэхүү бичлэг баримт болон компани дээр хадгалагдана. Өөр ямар нэгэн хэлбэрээр дуу, дүрс бичлэг хийхгүй.
- Хувьцаа эзэмшигч хурлыг аливаа хэлбэрээр үймүүлэх, зориуд саатуулах, бүдүүлэг үг хэллэг ашиглан бусдыг доромжлох, бусдын нэр төрийг гутаах, гүтгэхийг хориглоно.
- Согтууруулах мансууруулах төрлийн зүйл хэрэглэсэн, биеийн хэлэмж удирдах чадваргүй болсон, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хурлын үйл ажиллагаанд саад болсон тохиолдолд албадан хурлаас гаргана.
- Хурлын дэгийг зөрчсөн хувьцаа эзэмшигчид эхний удаа Хурлын дарга урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан хувьцаа эзэмшигчийг Хурлын даргын зөвшөөрлөөр Зохион байгуулах комисс хурлаас гаргах арга хэмжээг авна.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа санал хураалт явуулж, Тооллогын комисс хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг нэгтгэж, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулна.
- Хурлын дарга Тооллогын комиссын тогтоолд үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаасныг мэдэгдэнэ.

Та бүхэнд манай банкны жилийн ажлын тайлан тараагдсан байгаа. Тайланд банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан маш дэлгэрэнгүй байдлаар тусгагдсан. Мөн Кэй Пи Эм Жи аудит компанийн аудиталсан тайланг дүгнэлтийн хамт оруулсан байгаа.

Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу эхний асуудал болох Голомт банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал А.Одонбаатар танилцуулна.

Хэлэлцэх асуудал 1. Голомт банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга.

Танилцуулсан нь:

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа та бүхэнд маш их баярлалаа. Голомт банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах гэж байна.

- Хамгийн эхэнд 2024 оны Монгол улсын эдийн засгийн тоймыг танилцуулъя. Онцлох мэдээллүүд бол зудтай холбоотой хөдөө аж ахуйн салбараас бусдаар бол маш өсөлттэй жил болж өнгөрсөн. Дотоодын нийт бүтээгдэхүүн 4%-иар өссөн ийм жил болсон. Үүнийг дагаад банкны салбар мөн өсөлттэй, ялангуяа банкны салбарын нийт зээлийн өсөлт 37 их наядад хүрч, өмнөх оноос 35%-иар өссөн. Нүүрсний экспорт сайн байсантай холбоотой эдийн засгийн идэвхжил өндөртэй жил болсон.
- Голомт банкны хувьд 2024 онд дотоод үйл ажиллагаа, гадаад үйл ажиллагаа, санхүү гээд бүх чиглэлд маш амжилттай эерэг жил болсон. 2024 оны 5 сард олон улсад бонд гаргах замаар 300 сая ам. долларын бондыг оруулж ирсэн. Мөн оны 12 сард дахин 100 сая ам. долларыг олон улсын зах зээл дээрээс оруулж ирсэн. Олон улсын зах зээл дээрээс доллар оруулж ирнэ гэдэг нь, ямар нэгэн барьцаа хөрөнгө, засгийн баталгаагүйгээр Нью Йорк, Лондон, Хонг Конг, Сингапур зэрэг олон улсын хөрөнгө оруулагчид, хөгжлийн сангуудад Голомт банкны бондыг зарах замаар оруулж ирсэн байгаа. Мөн 2025 оны 1-р сард нийгмийн болон ногоон бондыг Люксембургийн ногоон бондын биржид амжилттай гаргасан. Үүн дээр онцлох зүйл нь бид 8%-ийн хүүтэй оруулж ирсэн нь Монгол улсын хувийн секторын хамгийн бага хувийн хүүтэй оруулж ирсэн тохиолдол болсон.
- Бизнесийн үйл ажиллагааны хувьд биетээр 5 салбар, лизингийн төвийг мөн нээж, амжилттай үйл ажиллагаа тэлсэн. Нийтдээ зээлийн багц 50%-иар өсч, хадгаламж депозит буюу иргэдээс татан төвлөрүүлсэн хөрөнгө 30%-иар өссөн үзүүлэлт гарсан. Голомт банкны зээлийн багцыг харвал иргэд, байгууллага, жижиг дунд бизнесийн гээд сайн тархсан бүтэцтэй байгаа.
- Голомт банк нийт 52 гадаадын банкин дахь дансаараа дамжуулан 15 төрлийн гадаад валютаар гадаад төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж байна. Ийнхүү олон улсын төлбөр тооцооны чиглэлд тэргүүлэх байр сууриа хадгалан Монгол улсын гадаад төлбөр тооцооны 36.2 хувийг бүрдүүлэв. Зах зээлд эзлэх хувийн хувьд мөн өсгөсөн.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Голомт банкны зээлжих зэрэглэл 2024 онд В+ болж өссөн. Fitch, Moody's S&P гэх гурван том үнэлгээний байгууллагаас В+ (В2) буюу тогтвортой гэсэн үнэлгээ авсан Монголын анхны банк болсон.

- Тогтвортой санхүүжилтийн хувьд Япон улсын MUFG банктай хамтран тогтвортой санхүүжилтийн хүрээгээ тодорхойлсон, үүн дээр S&P байгууллагаас хоёрдогч баталгаажилтыг амжилттай хийлгэсэн. JP Morgan банкаар дамжуулан Голомт банк Монгол улсын эдийн засагт ямар нөлөө үзүүлж байгаа талаар нөлөөллийн судалгаа хийлгэсэн, үүн дээр мөн өндөр үнэлгээтэй гарсан байгаа. Мөн олон улсын PCAF аргачлалаар өөрсдийн болон санхүүжүүлж буй зээлийн багцаас гаргаж буй хүлэмжийн хийн ялгарал ямар байгааг Монгол улсад анх удаа тооцож гаргасан. Монгол 2030 он гэхэд бид зээлийн ногоон багцыг нийт багцын 10%-д хүргэхээр зорьж ажиллаж байна. Өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийг 10%-иар бууруулна гэсэн зорилго тавьсан.
- Банкны үйл ажиллагаа бол ямагт эрсдэлийг тооцоолж ажилладаг. Зээлийн тэлэлттэй холбоотой зээлийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой олон төрлийн эрсдэлээс сэргийлсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Зээл цуглуулахтай холбоотой нэгж шинээр байгууллаа. Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын стандартуудыг бүрэн хангаж ажиллалаа. Зээлийн эрсдэлийн санг тооцоолдог олон улсын стандартыг амжилттай батлуулсан.
- Санхүүгийн үр дүн дараах байдлаар харагдаж байна. Нийт актив бол 15,5 их наяд хүрч, өмнөх онд 11,6 их наядаас даруй 4 их наядаар өссөн. Зээлийн багц 7,5 их наяд хүрч, өмнөх оноос 50 орчим хувиар өссөн. Нийт өөрийн хөрөнгө 1,4 их наядад хүрсэн. Зардал орлогын харьцаа, зээл эх үүсвэрийн харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар зэрэг санхүүгийн харьцаануудыг амжилттай өсгөж ажилласан. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ 14,7% буюу өмнөх оныхоос бага зэрэг буурсан нь бизнесийн үйл ажиллагааны тэлэлт, зээлийн багцын өсөлттэй холбоотой юм. Чанаргүй зээлийн харьцаа өмнөх оны үетэй харьцуулахад 3,0% болж буурсан байгаа. Голомт банкны сүүлийн 4-5 жилийн зээлийн багцын чанаргүй зээлийн хэмжээ сегмент бүрээр буурсан.
- Аудитын дараах цэвэр ашиг 419 тэрбум төгрөг гарсан. Үүнийг дагаад өөрийн хөрөнгийн өгөөж 33%, активын өгөөж 3,5% болж өссөн байна. 2024 онд чанаргүй зээлийн сангийн хүрэлцээг 120%-д хүргэсэн онцлох үзүүлэлттэй байна.
- Хувьцааны үнэ 2024 онд өсөлттэй байсан. Бондын үнэ анх гаргаснаас хойш тогтмол өсч байна.
- Хамгийн сүүлийн хэсэг бол IPO хийж байх үеийн танилцуулж байсан төсөөлөл болон 2024 оны гүйцэтгэл ямар байгааг харьцуулсан графикаар харуулж байна. Бүх үзүүлэлтийн хувьд IPO хийж байх үеийнхээс давуулан биелүүлсэн байна. Ганц төсөөлөлдөө хүрээгүй үзүүлэлт нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт байна.

Голомт банкны 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг товчхон танилцуулж дууслаа. Баярлалаа та бүхэнд.

Хурлын дарга Г.Ганболд: А.Одонбаатар захиралдаа баярлалаа. Дараагийн асуудал болох 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр танилцуулна.

Хэлэлцэх асуудал 2. Голомт банк ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Танилцуулсан нь:



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхтөр: Энэ жил Голомт банкны 30 жилийн ой тохиож байгаа, эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэнд Голомт банк үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн мэндийг хүргэе. Төлөөлөн удирдах зөвлөл 2024 онд олон улсын засаглалын зарчим, Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд ажилласан. Өөрийн эрх үүргийн хэмжээнд ТУЗ нь 2024 оны Голомт банкны стратеги төлөвлөгөөг баталсан. Энэхүү стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах бизнес төлөвлөгөө, бодлого, ажлын төлөвлөгөөг баталсан.

Бизнес төлөвлөгөө:

1. Корпорэйт бизнес төлөвлөгөө /Corporate BP/
2. Жижиг дунд бизнесийн бизнес төлөвлөгөө /SME BP/
3. Иргэдийн бизнесийн бизнес төлөвлөгөө /Retail BP/
4. Орон нутгийн бизнес төлөвлөгөө /Rural area BP/
5. Дижитал банкны бизнес төлөвлөгөө /Digital BP/
6. Хөрөнгө удирдлагын бизнес төлөвлөгөө /Treasury BP/
7. Гадаад эх үүсвэрийн бизнес төлөвлөгөө /Foreign funding BP/
8. Даатгалын бизнес төлөвлөгөө /Bancassurance BP/
9. Чанаргүй активын бууралтын бизнес төлөвлөгөө /SAD BP/

Бодлого болон ажлын төлөвлөгөө/action plan:

1. Актив, Пассивын удирдлагын бодлого /ALM policy/
2. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого /Information Security Policy/
3. Маркетингийн бодлого /Marketing policy/
4. Харилцагч төвтэй банкны бодлого /Customer Centric Banking Policy/
5. Хүний нөөцийн бодлого / HR policy/
6. Эрсдэлийн удирдлагын бодлого /Risk management policy/
7. Комплаенсийн бодлого /Compliance Policy/
8. Дата удирдлагын бодлого /Data management policy/
9. Зээлийн бодлого /Credit policy/
10. Мэдээллийн технологийн бодлого /IT policy/
11. Бизнес процессын удирдлагын бодлого /BPM policy/

Эдгээр баталсан төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтийг Аудитын хороогоор сар бүр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар улирал бүр хэлэлцэж, Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг хянадаг.

Голомт банкны 2024 оны стратеги төлөвлөгөөтэй уялдсан Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, дараах эрсдэлийн лимитүүдийг ТУЗ-өөс баталсан.

1. Зээлийн төвлөрлийн эрсдэлүүд;
2. Зээлийн багцад эзлэх эдийн засгийн салбарын төвлөрлийн эрсдэл;
3. Зээлийн чанарын эрсдэл;
4. Зах зээлийн эрсдэл;
5. Хөрвөх чадварын эрсдэл;
6. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл;
7. Үйл ажиллагааны эрсдэл зэргийг хамарсан нийт 46 эрсдэлийн лимитийг тогтоосон.

Эдгээр эрсдэлийн хязгаарлалт хэмжүүрүүдийн хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороогоор тогтмол хянаж ажилласан.

2024 онд сангаас хаасан зээлүүдийн тухайд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.1.4-т “Банкны үнэлгээгээр цаашид эргэн төлөгдөхгүй байх эрсдэлтэй гэж тооцогдсон муу ангилалтай активыг” тэнцлээс хасах шалгуурыг тодорхойлсон байдаг.

2024 онд нийт 5.6 тэрбум төгрөгийн, 651 харилцагчийн, 724 зээл, кредит картыг ТУЗ-ийн тогтоолын дагуу эрсдэлийн сангаас хаасан.

Голомт банкны 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүн, хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хянан үзээд “Голомт банк нь 2024 онд тавьсан зорилтуудаа давуулан биелүүлж, амжилттай ажилласан” хэмээн дүгнэсэн болно.

Хурлын дарга Г.Ганболд: Тус дүгнэлттэй холбогдуулан дараах шийдвэрийн төслийг батлуулахаар та бүхэнд танилцуулж байна.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Тогтоолын төсөл

Голомт банкны 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Голомт банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 17-ны ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүн, хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хэлэлцэх асуудал 3. 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав.

Танилцуулсан нь:

Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал Г.Соёлмаа: Сайн байна уу, Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Г.Соёлмаа гэдэг би Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ерөнхий захирал байна. Манай компани Голомт банкны 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэсэн. Бид аудитын төлөвлөлт болон үр дүнг танилцуулах явцад аудитын хороонд маш дэлгэрэнгүй танилцуулгуудыг хийсэн. Өнөөдөр товч байдлаар танилцуулъя.

Аудитын багийн бүрэлдэхүүнийг танилцуулав. Бид аудитын үндсэн бүрэлдэхүүнд Голомт банкинд хувьцаа эзэмшдэггүй, харилцагч биш хүмүүсийг томилон аудитын хараат бус байдлаа бүрэн ханган ажилласан.

Аудитын үр дүнгийн хувьд танилцуулагдсан 2024 оны жилийн тайланд манай аудитын тайлан бүрэн эхээрээ тусгагдсан байгаа. Аудитын тайлан дээр бид аудитын онцлох зүйлс, түүн дээр хийж хэрэгжүүлсэн аудитын горим, хүрсэн үр дүн, аудитын компанийн болон банкны удирдлагын үүрэг хариуцлага зэргийг дэлгэрэнгүй оруулсан байгаа.

Хараат бус аудитын үр дүнгээр Голомт банк ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэсэн аудитын эерэг үр дүн гарсан болно. Та бүхэнд амжилт хүсье!

Хурлын дарга Г.Ганболд: Баярлалаа. Энэ хөндлөнгийн хараат бус дүгнэлт бол ТУЗ дээр илүү дэлгэрэнгүй байдлаар танилцуулагдсан байгаа. Ингээд Голомт банкны 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой тайлан, тайланд хийсэн дүгнэлтүүдийг та бүхэнд танилцууллаа.

Танилцуулсан асуудлуудтай холбоотой эхний ээлжийн асуултууд асуух боломжоор хангая. Заалнаас асуулт асуух хувьцаа эзэмшигч нар гараа өргөнө үү.

Асуулт харнулт.

Хувьцаа эзэмшигч Чүгдэррагчаа: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 2024 онд ажилласан Голомт банкны удирдлагын багийн хамт олонд талархал илэрхийлье. Тайлан дээрээс харахад нийт олгосон зээлийг салбараар ангилан харуулсан боловч олгосон зээлийн үлдэгдлийг ангилсан үзүүлэлт тусгагдаагүй байна. Энийг тодруулж өгнө үү. Мөн банкнаас гарсан болзошгүй өр төлбөр, баталгаа батлан даалтын хэмжээ, балансын гадуурх бүртгэлийн мэдээлэл байхгүй байна. Энэ талаар мэдээлэл өгнө үү.

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Голомт банкинд сектор бүрээр баталсан зээлийн хязгаарлалтууд байдаг. ТУЗ-өөс энэ хязгаарлалтыг батлаад түүний дагуу зээл олгодог. 2024 оны байдлаар эрсдэлтэй гэж үзэж болох сектор бүрт 10-15 орчим хувийн лимиттэй ажилласан. Уул уурхайн салбарт 10%-ийн лимиттэй, үүнээс хэтрээгүй хэмжээгээр зээл олгосон байгаа.

Балансын гадуур бүртгэгдэнэ гэдэг нь зээл болон үүнтэй адилтгах хөрөнгийг эрсдэлийн сангаасаа хаагаад банк нь төлүүлэх гэж ажиллана, тэр болтол балансаас гадуур бүртгэхийг хэлдэг. Илүү дэлгэрэнгүй



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

байдлаар, мөн тодорхой тоон үзүүлэлтийг манай Санхүү удирдлагын газрын захирал Мөнхтуяа болон Эрсдэл хариуцсан захирал Отгон нар нэмж хариулна.

СУГ-ын захирал С.Мөнхтуяа: Манай аудитын тайлан бүтнээрээ манай вэбсайт дээр санхүүгийн хэсэгт орсон байгаа. Тус тайлангийн 40 дүгээр тодруулга “Болзошгүй өр төлбөр ба үүрэг” хэсгээс буслад гаргасан баталгаа, батлан даалт дүн дэлгэрэнгүй харж болно. Энд 2024.12.31-ний байдлаар 1,5 их наяд төгрөгийн нийт болзошгүй өр төлбөр, балансын гадуур үүрэг хүлээсэн байна.

Эрсдэл хариуцсан захирал Т.Отгон: Өглөөний мэнд хүргэе. Бидний хувьд бизнесийн зээл дээр эдийн засгийн сектор бүрт тодорхой лимитүүдийг мөрддөг. Эрсдэл өндөртэй секторууд дээр 5-10% лимит мөрддөг. Уул уурхайн салбарт 10% лимит мөрдөж ажилласан.

Хувьцаа эзэмшигч Түвшинбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Голомт банкны ногдол ашгийн бодлого анх танилцуулга дээрээ 40% гэж байсан. Энэ жил 20% гаруй байна. Ирэх жилүүдэд ямар бодлого баримтлах вэ? Энэ жил бол өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй холбоотой бага хэмжээтэй байна гэж ойлголоо.

ИРО хийх үед хувьцаа худалдан авсан жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ одоо 20%-иар доогуур байна. Энэ тал дээр ямар арга хэмжээ авах бодолтой байна вэ? Одоо нэмээд энгийн хувьцаа гаргах гэж байна гэж ойлгож байна. Энэ хувьцааны үнийг хэрхэн тогтоох вэ?

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Хоёрдахь асуултын тухайд дэлгэрэнгүй танилцуулга хийгдэнэ. Аливаа хувьцаат компанийн хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдаж байгаа хувьцааныхаа үнийг өсгөх, хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг өсгөх тал дээр өөрийн ашигт ажиллагааг нэмэгдүүлж ажиллах, мөн мэдээллийг ил тод хувьцаа эзэмшигчиддээ хүргэх гээд хоёр зүйл байдаг. Голомт банкны Гүйцэтгэх удирдлагын зүгээс энэ хоёр дээр 2024 онд онцгой анхаарч ажилласан. Ашигт ажиллагааны хувьд бол маш амжилттай ажилласан. Мэдээллийг ил тод хүргэх тал дээр хөрөнгө оруулагчидтай харилцах нэгж байгуулаад энэ нэгжээрээ дамжуулаад системтэй цэгцтэйгээр ил тод байдлаар хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэл хүргэхээр зорьж ажиллаж байна. Энэ хоёр дээр үндэслээд хувьцааны үнэ, эздийн хөрөнгө оруулалт, өгөөж өсөх ёстой. Өнөөдрийн байдлаар манай хувьцааны өөрийн хөрөнгөтэй харьцуулсан үнэ бол 1700 орчим төгрөг байгаа. Хөрөнгийн бирж дээр байгаа үнэ бол 1000 орчим төгрөг байна. Тэгэхээр хөрөнгийн зах зээл дээр харьцангуй хямд үнэлэгдэж байна.

Ногдол ашгийн бодлоготой холбоотойгоор болон 40% гэдэг нь манай Үнэт цаасны танилцуулга дээр дурдсан төсөөлөл юм. Бид 150 орчим тэрбумын ашигтай ажиллана, үүний 40%-ийг хөрөнгө оруулагч нартаа тараана гэж таамагласан. 2024 онд бид 419 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан, үүний ойролцоогоор 20%-ийг ногдол ашиг хэлбэрээр тараахаар шийдвэрлэсэн. Нэгж хувьцаанд ногдож буй дүнгээр харах юм бол бид өнгөрсөн жил 90 төгрөг байсан бол энэ жил 100 төгрөг олгогдохоор байгаа. Ногдол ашгаас гадна хувьцаа эзэмшигчдийнхаа урт хугацааны үнэ цэнийг хадгалж, өсгөх нь менежментийн багийн гол үүрэг байдаг. Үүнийг бид урт хугацаанд зорьж байгаа болохоор бизнесийн тэлэлтэнд анхаарсан ногдол ашгийн шийдвэр гаргасан. Бид нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийг жил бүр өсгөнө гэсэн бодлоготой байгаа. Хувиар илэрхийлвэл бизнесийн өсөлтийг хангах шалгуураа бариад хамгийн багадаа 20%-ийн ногдол ашиг олгоно гэсэн бодлого баримталж байгаа.

Хувьцаа эзэмшигч Мөнх-Эрдэнэ: 2024 онд удирдлагын зардал 70 тэрбумаар өссөн байна. Мөн валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй ч юмуу 40 тэрбумын гарзтай ажилласан байсан. Энэ зардал өсч байгаа нь ямар шалтгаантай вэ? Банк цахимжаад ирвэл зардал цаашид буурах уу? Мөн үйл ажиллагааны цэвэр ашиг нь 419 тэрбум төгрөг гэж байгаа мөртлөө мөнгөн гүйлгээний тайлан дээрээ -240 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байгаа нь энэ компани мөнгөн байдлаараа ашиг олоод байгаа юмуу эсвэл аккрузал байдалтай авлага өглөг хийсэн үнэлгээний асуудлууд байна уу?

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Түрүүн тайлан дээр дурдсанчлан 2024 онд 5 биет салбар байгуулсан лизингийн төв байгуулсан, 2024 оны 5 сард ажилтнуудынхаа цалинг 20 хүртэл хувиар нэмсэн. Энэ нь органик өсөлттэй холбоотой зардлын өсөлт байгаа.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Бид хүүгийн бус орлого дээрээ 80 орчим тэрбумын ашигтай байгаа. Ямар нэгэн валютын үйл ажиллагаанаас хамаарч алдагдал хүлээсэн зүйл байхгүй байгаа.

СУГ-ын захирал С.Монхтуяа: Банкны хувьд актив пассивын балансыг харвал пассив талдаа валютын эх үүсвэртэй актив бол валютын зээл гаргадаггүй. Ностро дансан дээр бага зэрэг мөнгө байдаг. Тэгэхээр валютын зохицуулалт хийх үед ханш зах зээл дээр өссөн үед ийм алдагдал хүлээдэг. Үүнтэй зөрүүлээд гадаад валютын арилжаанаас үүссэн олз дээр 102 тэрбум төгрөг бий. Тэгэхэд банк позицоо зохицуулаад энэ хоёрын зөрүүгээр ашиг орлого тооцогддог. Энэ нь тайлан дээр тус тусдаа бичигдээд нийт цэвэр дүнгээрээ 60 тэрбум төгрөгийн валют арилжааны ашигтай байгаа.

Банкны мөнгөн гүйлгээ дотор зээл, хадгаламжийн үндсэн үйл ажиллагаа байгаа. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд үнэт цаас, хувьцаа бонд гээд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгүүдээ байршуулдаг хэсэг байгаа. Тэрэн дээр бид 207 тэрбум төгрөгийн ашигтай байгаа.

Хурлын дарга Г.Ганболд: Дараагийн шийдвэрийг та бүхэнд танилцуулъя. Ногдол ашгийн тогтоол байгаа.

Хэлэлцэх асуудал 4. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг хурлын Дарга Г.Ганболд танилцуулав.

Ногдол ашгийн тогтоол

Хурлын дарга Г.Ганболд: Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.02.17-ны өдрийн 00/01 дугаартай тогтоолоор Голомт банкны 2024 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 100 (нэг зуу) төгрөгөөр тооцож, ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсөн шийдвэр гарсан.

ТУЗ-ийн шийдвэр гаргасан огноо:	2025.02.17
Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:	2025.03.26 /Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр/
Нэгж хувьцаанд олгох ногдол ашиг:	100 төгрөг
Нийт олгох ногдол ашгийн хэмжээ:	80,865,730,600 төгрөг
Зохицуулагч байгууллагаас ногдол ашиг тараах зөвшөөрөл олгосон хугацаа:	Хүлээгдэж байна
Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан хугацаа:	2025 оны 4 дүгээр сард багтаан тараана

Санхүүгийн зохицуулах хорооны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Хувьцаат компани нь зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр тараана.

Хурлын дарга Г.Ганболд: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу “2024 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлын тайлан, 2025 оны төсвийг танилцуулж батлах” асуудлыг ТУЗ-ийн НБД З.Солонго танилцуулна.

5. 2024 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ажлын тайлан, 2025 оны төсвийг танилцуулж батлах.

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга З.Солонго: Сайн байцгаана уу, миний бие З.Солонго ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байна. ТУЗ-ийн 2024 оны ажлын тайлан болон 2025 оны цалингийн төсвийг батлуулахаар саналыг танилцуулна.

- Голомт банкны засаглалын бүтцийг танилцуулав:



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийг томилдог ба ТУЗ нь байнгийн үйл ажиллагаатай дөрвөн Хороотой, Аудитын хороо, Засаглал ёс зүй цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Эрсдэлийн удирдлагын хороо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулья.

2024 онд Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь:

- 4 ээлжит
- 21 ээлжит бус (нийт 25)
- 66 асуудал хэлэлцэж
- 49 тогтоол (шийдвэр) гаргасан байна.

Шийдвэрүүдийг ангилж үзвэл:

Стратеги, бизнес төлөвлөгөөтэй холбоотой:

- ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 11 хэлэлцүүлэг болсны үндсэн дээр нийт 12 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Хөрөнгө оруулалттай холбоотой:

- ТУЗ-ийн хурал, Хороодын хурлаар 8 хэлэлцүүлэг болсны үндсэн дээр нийт 18 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт сайжруулах:

- Нийт 8 шийдвэр гаргаж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Бодлогын баримт бичиг, дүрэм журам, засаглалыг сайжруулах:

- Нийт 13 бодлого журмыг сайжруулан шинэчилсэн байна.

Аудитын хорооны бүрэлдэхүүнийг харвал Хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жэймс Б. Двайер. Хорооны гишүүдийн хувьд 5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Тус хороо 2024 онд нийт 10 удаа хуралдсан. Нийт 40 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал:

Банкны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн үр дүн;

Дотоод аудитын тайланг тайлагнах;

Дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тайлагнах, төлөвлөгөөг батлуулах;

Монголбанкны шалгалтын үр дүн;

Хөндлөнгийн аудитын үр дүн;

Бусад гэж ангилж болно.

Эрсдэлийн удирдлагын хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Александр Пикер.

Хорооны бүрэлдэхүүний хувьд 5 гишүүний дийлэнх буюу 3 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Эрсдэлийн удирдлагын хороо нь 2024 онд нийт 29 удаа хуралдсан. Нийт 94 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал:

83% нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс зээлтэй групп компаниудын хүсэлтийг шийдвэрлэсэн Зээлийн хорооны хяналт;

12% нь Эрсдэлийн тайлан мэдээлэл, эрсдэлийн удирдлага бодлого;

5% нь бусад цаг үеийн асуудал, мэдээлэл байна.

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Жэймс Б. Двайер.

Хорооны бүрэлдэхүүний хувьд 3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо нь 2024 онд нийт 3 удаа хуралдсан. Нийт 4 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хэлэлцсэн асуудал:

Тус хорооны дүрмийн нэмэлт, өөрчлөлт, баримт бичгийн хэрэгжилт;

Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв;

Цалин урамшууллын бодлого, Гүйцэтгэх удирдлагын багийн гүйцэтгэл, урамшуулалтай холбоотой байна.

Нэр дэвшүүлэх хорооны Дарга ТУЗ-ийн Хараат бус гишүүн Александр Пикер.

Хорооны бүрэлдэхүүний хувьд 3 гишүүний дийлэнх буюу 2 гишүүн ТУЗ-ийн Хараат бус гишүүн.

Нэр дэвшүүлэх хороо нь 2024 онд нийт 3 удаа хуралдсан.

Нийт 6 асуудал хэлэлцэж холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Хэлэлцсэн асуудал:

Тус хорооны дүрмийн нэмэлт, өөрчлөлт;

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалт;

Бүтэц зохион байгуулалт, Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, төсөв.

Гүйцэтгэх удирдлагын нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой байна.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ болон Хороодын хурал нийт 70 удаа хуралдсан байна. Энэ нь долоо хоногтоо хамгийн багадаа 1 удаа, сардаа 5-6 удаа хуралдсан, маш их ачаалалтай ажилладаг чадварлаг бүтэц бүрэлдэхүүнтэй ТУЗ байгаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалингийн төсөв 1,424 сая төгрөгөөр батлуулах саналыг өргөн барьж байна. Үүнд:

	Сард		Жил		Total budget for AGM
	Цалин	НДШ бай 12.5%	жил	НДШ бай 12.5%	
Жилийн төсөв /одоо/	111,028,850	7,657,287	1,332,346,205	91,887,442	1,424,233,648

Хурлын дарга Г.Ганболд: Танилцуулгын дагуу батлах асуудал бол ТУЗ-ийн 2025 оны төсөв байгаа. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 17-ны өдрийн ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалингийн төсвийг хавсралтаар баталсугай.

Хэлэлцэх асуудал 6. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга.

Дотоод аудитын газрын захирал А.Туяа: Энэхүү танхимд хүрэлцэн ирсэн та бүхэнд болон онлайнаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн сонгуульд 4 ердийн гишүүд, 5 хараат бус гишүүд нэр дэвшиж байна.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Танилцуулсан нь:

1. Ердийн гишүүнд нэр дэвшигчид:

Ч.МӨНХЦЭЦЭГ

Боловсрол:

- Зөвлөлтийн 3-р дунд сургууль, (1978-1988)
- Политехникийн ИС, УУЦМеханик инженер, (1988-1993)
- АНУ-ын Жонс Хопкинсийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1999-2001)
- АНУ-ын Харвардын ИС, Удирдлагын манлайллын хөтөлбөр, (2015)
- Англи улсын Оксфордын ИС, Удирдлагын хөгжлийн хөтөлбөр, (2016)

Ажлын туршлага:

- Монголын Хөрөнгийн бирж, Гадаад харилцааны албаны дарга, (1996-1998)
- Дэлхийн банк, Төслийн ко-ординатор, (2004)
- Азийн сан, Төслийн стратеги, хөгжлийн хэлтсийн дарга, (2004-2007)
- Нэпко хэвлэлийн компани, Гүйцэтгэх захирал, (2007-2010)
- Тойм сэтгүүл, Эрхлэгч, Үүсгэн байгуулагч, (2010-2012)
- УБ дахь ОУ-ын сургууль, ТУЗ-ийн гишүүн, (2004-2014)
- Монгол масс медиа ХХК, ТУЗ-ийн гишүүн, (2014-2018)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, дарга (2012 - одоог хүртэл)

Ж.ҮНЭНБАТ:

Боловсрол:

- Нийслэлийн 30-р болон 14-р дунд сургууль, (1970-1980)
- ЗХУ-ын Москва хотын эдийн засаг статистикийн ДС, Эдийн засагч, статистикч, (1980-1985)
- АНУ-ын Колумбын их сургууль, Олон улсын харилцааны мастер (1993-1994)

Ажлын туршлага:

- Монгол банк, Мэргэжилтэн, Газрын дарга, (1990-1996)
- Монгол банк, Ерөнхийлөгч (1996-2000)
- Азийн хөгжлийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Дэлхийн банк, МУ-ыг хариуцсан Захирагч, (1998-1999)
- Монголын банкны холбоо ТББ, Гүйцэтгэх захирал, (2000-2006, 2015-2020)
- Монгол банк, Хяналтын зөвлөлийн гишүүн, (2004-2016)
- Монголын Уул уурхайн корпорац, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2010-одоог хүртэл)
- АПУ ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2015 – одоог хүртэл)
- Нээлттэй нийгэм форум ТББ, Удирдах зөвлөлийн гишүүн, (2016 – одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн, (2011-2019)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2020 – одоог хүртэл)

О.ГАНЖОЛОО

Боловсрол:

- Монгол-Оросын хамтарсан 2-р дунд сургууль, (1984-1994)
- МУИС, Банк, Санхүү, (1994-1997)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (1997-2002)
- ХБНГУ-ын Чөлөөт ИС, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, (2006-2008)
- Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч

Ажлын туршлага:

- Голомт банк, Санхүүгийн хяналтын газар, мэргэжилтэн, (2003)
- Бодь групп ХХК, ХБНГУ дах Төлөөлөгчийн газар, ажилтан, (2004-2005)



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, ХБНГУ, Зөвлөх, (2008-2010)
- ПрайсУотерХаус Куперс Аудит ХХК, Монгол Улс, Ахлах зөвлөх, (2010-2011)
- Бодь интернэшнл ХХК, Санхүү хариуцсан захирал, (2011-2018)
- Голомт санхүүгийн нэгдэл ХХК, Гүйцэтгэх захирал, (2016-2023)
- Голомт банкны ТУЗ-ийн ердийн гишүүн (2022-одоог хүртэл)
- Цэцэнс майнинг энд энерги ХХК, Санхүү хариуцсан захирал (2024-одоог хүртэл)

Д.МӨНХТӨР

Боловсрол:

- Завхан аймгийн 3-р дунд сургууль, (1983-1993)
- МУИС, Банк, Санхүү, Бакалавр, (1993-1997)
- АНУ-ын Оклахомагийн ИС, Бизнесийн Удирдлагын магистр, (2007-2009)

Ажлын туршлага:

- Голомт банк, Эдийн засагч, (1997-1999)
- Голомт банк, Зээлийн газрын захирал, (1999-2007)
- Голомт банк, Бүртгэл тооцооны газрын захирал, (2009-2011)
- Голомт банк, Үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал, (2011-2014)
- Бодь Интернэшнл ХХК, Дэд захирал, Төслийн удирдагч, (2014-2019)
- Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК, Гүйцэтгэх захирал, (2019-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн ердийн гишүүн, (2012-одоог хүртэл)

Хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

ЖЭЙМС Б.ДВАЙЕР

Боловсрол:

- АНУ-ын Нотр Дамын ИС, Бизнесийн удирдлагын бакалавр (1961-1965)
- АНУ-ын Колумбын ИС-ийн Бизнесийн сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1968-1970)

Ажлын туршлага:

- UBS банк, Компанийн нэгдэл, компани худалдан авах процесс хариуцсан захирал (1970-1984)
- Компанийн хөгжлийн холбоо, Ерөнхийлөгч (1984-1985)
- KPMG Зөвлөх үйлчилгээ, Хөрөнгө оруулалтын банкны зөвлөх (2001-2003)
- Хойд Америк-Монголын бизнес зөвлөл, Үйл ажиллагаа хариуцсан захирал (2003-2007)
- Монголын урлагийн зөвлөл, Дэд тэргүүн (2007-2011)
- Жиант Степпес оф Жазз, Дэд тэргүүн (2006-2012)
- Эдийн засаг, бизнесээр мэргэшиж буй оюутнуудын олон улсын холбооны Монгол дахь зөвлөл, ТУЗ-ийн дэд дарга (2009-2012)

- Монголын хөгжлийн нөөц ХК, ТУЗ-ийн гишүүн (2010-2014)
- Монголын бизнесийн зөвлөлийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дэд дарга (2007-2017)
- Монголын боловсролын сан, Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга (2012-одоог хүртэл)
- Мандал даатгал ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2012-одоог хүртэл)
- Монголжин прайвит капитал, ТУЗ-ийн дэд дарга (2013-одоог хүртэл)
- Монголын хөгжлийн групп, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2014-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2017-одоог хүртэл)
- Монголын финтек групп ХК, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2018-одоог хүртэл)
- Монголын бизнес мэдээллийн сан, Хамтрагч/ТУЗ-ийн гишүүн (2018-одоог хүртэл)

АЛЕКСАНДР ПИКЕР

Боловсрол:

- Австри улсын Зальцбургийн ИС, Бизнес, Хуулийн чиглэлээр магистр, доктор (1982-1989)



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Ажлын туршлага:

- Австри улсын Die ERSTE банк, Төслийн санхүүжилтийн ахлах ажилтан (1990-1993)
- Австри улсын хяналтын банк, ЗХУ харицсан ахлах ажилтан (1993)
- ОХУ-ын Москвагийн олон улсын банк, Байгууллагын банкны газрын ахлах менежер, Захирал, Эрсдэл хариуцсан захирал (1994-1999)
- Польш улсын BPH банк, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Эрсдэл хариуцсан захирал (1999-2004)
- Серби улсын Unicredit банк, Гүйцэтгэх захирал (2004-2007)
- Казакстан улсын JSC ATF банк, Гүйцэтгэх захирал (2007-2010)
- Европын Unicredit групп, Дэд ерөнхийлөгч (1994-2011)
- Нуро Alpe-Adria банкны Чех, Босни ба Херцеговина, Австри улс дах салбаруудын Гүйцэтгэх захирал (2011-2015)
- Итали улсын Нуро банк, ТУЗ-ийн дарга (2014-2015)
- Серби улсын Komercijalna банк, Гүйцэтгэх захирал (2015-2017)
- Transparency International-н Австрийн салбар, Гүйцэтгэх захирал (2018-2019)
- Герман улсын AlixPartners, Хараат бус гэрээт ажилтан (2018-2019)
- Австри улсын BCB4U, Гүйцэтгэх захирал (2019)
- Pendl & Piswanger, ТУЗ-ийн зөвлөх гишүүн (2019-одоог хүртэл)
- Дэлхийн банкны төслүүд, Ахлах зөвлөх (2019-одоог хүртэл)
- Австри улсын Крипто Бирж, Зөвлөх (2020-одоог хүртэл)
- Узбекистан улсын Ipoteka банк, Хяналтын зөвлөлийн дарга (2020-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2021-одоог хүртэл)
- Бүгд Найрамдах Молдав Улсын Moldindconbank банкны Гүйцэтгэх захирал (2023-одоог хүртэл)

РОБЕРТ В. ВАН СВИТЕН

Боловсрол:

- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, Хуульч (1980-1986)
- АНУ-ын Колумбын их сургууль, Хууль зүйн магистр (1987-1988)
- Нидерландын Хаант Улсын Лейдны ИС, ОУ-ын эдийн засгийн магистр (1986-1991)
- АНУ-ын Чигако их сургууль, Бизнесийн удирдлагын магистр (1994-1996)

Ажлын туршлага:

- НХУ-ын Royal Vopak, Хуульч, Евро бүсийн хариуцсан менежер, (1985-1990)
- ABN Amro Bank, АНУ, БНСУ, НХУ-ууды салбаруудад дэд ерөнхийлөгч (1990-1998)
- General electric, Санхүүч (1998-2002)
- Lehman brothers, Лондон, Нью-Йорк, Франкфурт, Токио салбаруудад Үйл ажиллагаа хариуцсан захирал (2002-2005)
- Сингапурын хөрөнгийн бирж, Санхүүч хариуцсан захирал (2006-2007)
- Стандарт банк, Сингапур салбар (2007-2008)
- Азийн хөгжлийн банк, Хувийн салбарын хөрөнгийн зах зээлийн салбарын захирал (2009-2012)
- АНУ-д төвтэй EMPEA, Гүйцэтгэх захирал, (2013-2017)
- Хонг Бао Медиа Холдингс ХХК "Hong Bao Media Holdings Pte Ltd", ТУЗ-ийн гишүүн, Санхүүгийн хорооны дарга (2016-одоог хүртэл)
- АНУ-д төвтэй Serendra group, Гүйцэтгэх захирал (2017-одоог хүртэл)
- Сий Ойл Филиппин корпораци, ТУЗ-ийн гишүүн, Засаглалын хорооны дарга (2022-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2023-одоог хүртэл)

ХАНС ХОЛЗХАКЕР

Боловсрол:

- БНАУ-ын Венийн ИС, Нийгмийн ухааны сургууль, Социологийн докторант (1972-1984)



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- БНАУ-ын Венийн ИС, Эдийн засгийн сургууль, Эдийн засгийн шинжлэх ухааны магистр (1985-1988)
- БНАУ-ын Ахисан түвшний судалгааны хүрээлэн, Эдийн засаг (1988-1989)

Ажлын туршлага:

- Венийн Техникийн Их сургууль, Судалгааны ажилтан, үйлдвэрийн зохион байгуулалтын төсөл, Эрдэм шинжилгээний ажилтан (1980-1984)
- Номура судалгааны хүрээлэн, Төв Европын эдийн засагч (1989-1993)
- ГироКредит Судалгаа /GiroCredit Research/, Австрийн хөрөнгө оруулалтын банк, "Улс орны эрсдэл/судалгаа" хариуцсан захирал (1993-1999)
- Олон улсын санхүүгийн хүрээлэн, Чех, Словак, Словени, Украиныг хариуцсан ахлах эдийн засагч (1999-2001)
- ЮниКредит группын Банк Австри Кредитанштальт, ТЗЕ-ын орнуудын үнэлгээг хариуцсан ахлах эдийн засагч (2001-2008)
- ЮниКредит группын ATF Банк, Ерөнхий эдийн засагч (2008-2013)
- Narxoz их сургууль / Т.Рыскуловын нэрэмжит Шинэ эдийн засгийн их -сургууль, Шинжлэх ухааны ахлах зөвлөх (2014-2016)
- Голомт банк, Ерөнхий эдийн засагч (2016-2017)
- Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Төв Азийн тэргүүн эдийн засагч, дэд захирал (2017-2019)
- Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээлэн (CAREC Institute), Ерөнхий эдийн засагч (2020-одоог хүртэл)
- Голомт банк, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2024-одоог хүртэл)

РОНИЛ СҮЖАН

Боловсрол:

- АНУ-ын Мүленберг Коллеж, Эдийн засгийн ухааны бакалавр (1986-1990)
- АНУ-ын А&М ИС, Бизнесийн улирдлагын магистр (1991-1993)
- Сингапур Улсын Үндэсний ИС, Үл хөдлөх хөрөнгийн санхүүжилт (2001-2002)
- Франц Улс дах INSEAD, Ахлах манлайллын хөтөлбөр (2011-2012)
- АНУ-ын Станфордын ИС, Байгууламжийн менежментийн мэргэжилтэн (2013-2014)

Ажлын туршлага:

- Нэгдсэн Технологийн корпорац, Үйл ажиллагааны аналит (1990-1993)
- ПрайсУотерХаус, Зөвлөх (1993-1994)
- Энэтхэг Улс дах Америкийн банк, Туслах дэд ерөнхийлөгч (1994-1996)
- Лондон дах ANZ банк, Дэд захирал (1996-1998)
- Рабобанк групп, Энэтхэг дэх Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагч удирдлагын баг (1998-2005)
- Рабобанк групп, Удирдах захирал, Амьдралын ухаан, технологийн банкны захирал (2005-2008)
- Рабобанк групп, Ази-Номхон далайн бүс хариуцсан захирал, Удирдах захирал (2008-2012)
- Савиллс Сингапур, Стратегийн ахлах зөвлөх (2013-2015)
- Энэтхэг Улсын Мумбай хот, Тилакнагар Индастрийс Лимитед, Хараат бус гишүүн (2013-2016)
- Сингапур, M Social/Up, ТУЗ-ийн дарга (2016-2022)
- Нью Йорк хот, DrumG Financial Technologies Greater, ТУЗ-ийн гишүүн, хөрөнгө оруулагч (2018-2022)
- Ази, Ойрхи Дорнод, St.James's Place, Стратегийн зөвлөх (2020-2023)
- Недерланд, Стювард Рэдквийн, Ахлах зөвлөх (2021-2024)
- Сингапур Улсын Үндэсний ИС, Инновацийн тэтгэлэгт хөрөнгө оруулалтын хороо/орон тооны бус -факультет (2013-одоог хүртэл)
- Раага Холдингс ХувийнХК, Хамтран үүсгэн байгуулагч, ГЗ. Үйл ажиллагаа хариуцсан захирал (2013-одоог хүртэл)
- INSEAD, Оршин суугаа газар дах орон тооны бус бизнес эрхлэгч (2017-одоог хүртэл)



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

- Омнивор Партнерс, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2018-одоог хүртэл)
- Мега Делта Капитал, ТУЗ-ийн хараат бус гишүүн (2018-одоог хүртэл)
- Азийн Удирдлагын хүрээлэн, Орон тооны бус факультет (2022-одоог хүртэл)

Хурлын дарга Г.Ганболд: ТУЗ-д нэр дэвшиж байгаа ихэнх гишүүд хуучин ажиллаж байсан хүмүүс байгаа. Манай дотоодоос нэр дэвшиж байгаа хүмүүс энэ танхимд байгаа асуулт асууж болно. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар сонгоно. Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 17-ны өдрийн ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан дор дурдсан нэр дэвшигчдийг “Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр 2028 оны ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл гурван жилийн хугацаатай сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1. Чүлтэмийн Мөнхцэцэг;
 - 1.1.2. Жигжидийн Үнэнбат;
 - 1.1.3. Дагвын Мөнхтөр;
 - 1.1.4. Очирпүрэвийн Ганжолоо.
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1. Жэймс Б. Дваер;
 - 1.2.2. Александр Пикер;
 - 1.2.3. Роберт В. Ван Свитен;
 - 1.2.4. Ханс Холзхакер;
 - 1.2.5. Ронил Сүжан.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд холбогдох хууль тогтоомж, банкны дүрэм, компанийн засаглалтай холбоотой журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар олон нийтэд мэдээлж, гишүүдийн мэдээллийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /З.Солонго/-д даалгасугай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдтэй хөдөлмөрийн харилцааг зохицуулах гэрээний нөхцөлийг тохирч, гэрээнд банкныг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ч.Мөнхцэцэг/-д олгосугай.

Хурлын дарга Г.Ганболд: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай Гүйцэтгэх захирал А.Одонбаатар танилцуулна.

Хэлэлцэх асуудал 7. Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай

Танилцуулсан нь:

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Та бүхэнд дахин өдрийн мэнд хүргэе. Дараагийн танилцуулга бол банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх, нэмж гаргавал 12 хүртэлх хувийн тэргүүн ээлжид худалдан авах эрхээс татгалзах тухай шийдвэр гаргуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хүсч



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

байна. Голомт банк нь өнөөдрийн байдлаар 900 орчим сая ширхэг зарласан хувьцаатай байгаа. Үүнээс 808 сая ширхэг орчим нь гаргасан буюу олон нийт эзэмшиж байгаа хувьцаа байна. Бид 900,000 ширхэг хувьцаагаа 250,000 ширхэгээр нэмэгдүүлэн 1,150,000,000 ширхэг болгох санал гаргаж байна. Үүний шалтгаан нь Голомт банк сүүлийн 10 гаруй жил IPO хийх, олон улсын зах зээлд гарах стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Өмнөх санхүү үйл ажиллагааны тайланд дурьдсанчлан түүний дараа 2024 онд нийтдээ 450 сая ам. долларын бондыг олон улсын зах зээл дээрээс хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлж чадсан.

2022 оны сүүлээр Монголын хөрөнгийн бирж дээр анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон олон нийтээс 11.43 хувьтай тэнцэх хөрөнгийг татан төвлөрүүлж 2023 онд албан ёсоор МХБ дээр бүртгэлтэй нээлттэй компани болсон.

Дараагийн төлөвлөж буй ажил нь олон улсын санхүүгийн зах зээл дээр буюу олон улсын санхүүгийн төвүүд дээр хувьцаагаа шууд гаргах юм. Энд ямар шаардлага хэрэгцээ байгаа вэ гэхээр манай банкны засаглалын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, ТУЗ-ийн бүтэц, санхүүгийн үр дүн, тайлагнал гээд бүх зүйл олон улсын түвшинд хүрсэн байна. Бид энэ үйл ажиллагаа, давуу талуудаа ашиглаад олон улсын зах зээлд гарахаар төлөвлөж байгаа.

Сүүлийн 2 жилийн банкны өсөлт, тэлэлттэй холбоотой өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 14,7 хувь болсон байгаа. Бид энэ үзүүлэлтийг нэмэгдүүлэх замаар дараагийн өсөлт хөгжилтийн стратегийг хэрэгжүүлснээр хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнэ нэмэгдэнэ.

Зарласан хувьцааг нэмэгдүүлнэ гэхээр тухайн хувьцааг та бүхэнд мэдэгдэхгүйгээр хэн нэгэнд зарна гэж ойлгодог нь буруу юм. Олон улсын зах зээлд гарах ажиллагааны явцад нэмж хувьцаа гаргахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн шийдвэр шаардлагатай болно. Харин хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулна гэдэг 45 хоног хүлээх зэрэг маш урт хэцүү процесстэй ажиллагаа болдог учир хувьцаагаа бид нэмж гаргахаар болоход дахин хурал зарлаад санал аваад нийт Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ эдлэх эсэхийг 21 мянган хувьцаа эзэмшигчдээс асуулга явуулах нь цаг хугацаа, ажиллагааны хувьд хүндрэлтэй учраас урдчилан энэхүү тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар саналыг оруулж байгаа юм.

Бидний эдгээр хичээл зүтгэл, олон улсын зах зээлд бонд гаргасан гэх зэрэг үйл ажиллагаа нь өөрсдийгөө дэлхийд таниулах, олон улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нээлттэй компани болох Банкны хэтийн зорилготой холбоотой. Тэгэхээр бид одоо олон улс болон дотоодын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа нэмэлтээр гаргахаар зорьж, судалж ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор бид нэмж хувьцаа гарган өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж бизнес ээ улам тэлэх хүсэлтэй байгаа учир, банкны заралсан хувьцааны тоогоо нэмэх шаардлагатай байгаа юм.

Энэ шийдвэр хэрэгжиж гарлаа гэхэд олон нийт эзэмшиж байгаа хувь 11,6% байгаагаас 20,6% болж өснө. Нэг хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл 81,8% байгаагаас 73.5% болж буурна. Зарласан хувьцаагаа нэмэгдүүлээд үүнийгээ олон нийтэд гаргаж чадвал олон нийт эзэмшиж байгаа хувь 37,8% болж өсөн том хувьцаа эзэмшлийн хувь 57,5% болж буурах юм.

Хурлын дарга Г.Ганболд: Танилцуулгын дагуу батлах асуудал бол Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай байна. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

**Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхгийг нэмэгдүүлэх,
нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхийн тухай**

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дүгээр зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, “Голомт банк” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.2.10 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04-р сарын 17-ны өдрийн ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

1. Компанийн зарласан хувьцааг 1,150,000,000 (нэг тэрбум нэг зуун тавин сая) ширхэг болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн гаргасан энгийн хувьцааны 12 (арван хоёр) хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг нэмж гаргахад нийт хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн дүрэмд заасан зарласан хувьцаанаас нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, үе шаттайгаар олон нийтэд санал болгох хугацааг тодорхойлох зэрэг хувьцаа нэмж гаргахтай холбогдох бусад шийдвэрийг тухай бүр гаргаж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болохыг дурдсугай.

Хурлын дарга Г.Ганболд: Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Банкны дүрэм өөрчлөн батлах тухай ТУЗ-ийн НБД 3.Солонго танилцуулна.

Хэлэлцэх асуудал 8. Банкны дүрэм өөрчлөн батлах тухай.

Танилцуулсан нь:

Банкны ТУЗ-ийн НБД 3.Солонго: Гүйцэтгэх захирлын танилцуулсан Голомт банкны зарласан хувьцааг нэмэгдүүлэх асуудалтай холбоотой банкны дүрэмд өөрчлөлт оруулах шаардлага үүсч байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм Голомт банк 2022 оны сүүлээр олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгож албан ёсоор 2023 оны 02 сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 00/02 Шийдвэрээр баталсан Хувьцаат компанийн дүрэм болно.

Тиймээс одоо байгаа дүрмийн заалтыг танилцуулья.

Дүрмийн 3 дугаар зүйл болох Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа хэсэгийн 3.2 дахь заалтад “Банк нь 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 900,000,000 (есөн зуун сая) ширхэг энгийн, 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000,000 (хоёр зуун сая) ширхэг давуу эрхийн зарласан хувьцаатай байна гэж заасан.

Энэхүү заалтын 900,000,000 энгийн хувьцааны тоог 250,000,000-аар нэмэгдүүлж 1,150,000,000 болгох санал өргөн барьж байна. Шийдвэрийг төслийг хурлын Дарга танилцуулах уу?

Хурлын дарга Г.Ганболд: Танилцуулгын дагуу батлах асуудал бол Голомт банкны дүрмийг батлах тухай байна. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулья.

Тогтоолын төсөл

Голомт банкны дүрмийг батлах тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Голомт банкны дүрмийн 8.2.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 17-ны ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Голомт банк” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг доорх байдлаар өөрчилсүгэй:
- “3.2. Банк нь 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,150,000,000 (нэг тэрбум нэг зуун тавин сая) ширхэг энгийн ... зарласан хувьцаатай байна”

Хурлын дарга Г.Ганболд: Дараагийн танилцуулах асуудал болох Хувьцаа эзэмшил өөрчлөгдөх тухай асуудлыг ТУЗ-ийн НБД мөн танилцуулна.

Хэлэлцэх асуудал 9. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Танилцуулсан нь:

Банкны ТУЗ-ийн НБД 3.Солонго: Голомт банк ХК-ийн одоогийн хувь эзэмшлийн бүтцийг танилцуулая. Голомт Файнэншил Групп компани 77.2%, Бодь Интернэшнл ХХК шууд 3.42%, шууд бусаар өөрийн 100%-ийн охин компаниар дамжуулан 2.57% буюу нийтдээ 5.99% эзэмшдэг болно. Швецарийн 5.21%, олон нийтэд нээлттэй арилжаалагдаж байгаа 11.6% байна.

Голомт Инвестмэнт Лимитед нь хэрхэн Голомт банкны хувьцааг эзэмших болсон талаар товчхон мэдээлэл өгье:

- Трафигура Бэхээр Би.Ви компани Голомт банкинд хөрөнгө оруулсан байсан, гэвч тус компани нь Монгол Улсад хөрөнгө оруулах стратегийн өөрчлөлтөөс үүдэн Голомт банкны хувьцаа эзэмшлээс гарах хүсэлтээ илэрхийлсэн,
- Энэхүү асуудлыг Голомт банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 00/04 дугаар шийдвэрлэсэн,
- Трафигура компанийн 20,800,000 ширхэг энгийн хувьцаа нь “Хувьцаа худалдах, худалдан авах” гэрээний дагуу шилжсэн;
- Монголбанкинд шаардлагатай бүх бичиг баримтуудыг илгээн шалгуулж, урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр Бодь Интернэшнл ХХК нь худалдан авах төлбөрийг шилжүүлсэн;
- Худалдагчийн хүсэлтээр тус хувьцаа нь Голомт Инвестмэнт Лимитедэд компанид шилжсэн.

Хувьцаа эзэмшил өөрчлөгдөх одоогийн үйл ажиллагаа:

- Бодь Интернэшнл ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/37 дугаар албан бичгээр болон 2025 оны 03 сарын 06-ний 02/25 тоот ТУЗ-ийн Тогтоолоор:
- Голомт Инвестмэнт Лимитед компанийг татан буулгах үйл ажиллагааг эхлүүлж, тус ажлыг хариуцан ажиллах комисс томилж буй тухай мэдэгдсэн;
- Үүнтэй холбогдуулан тус компанийн бүх хөрөнгө болон хөрөнгийн эрхийг цорын ганц 100% хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэшнл ХХК-д шилжүүлэх;
- Үүнд: Голомт Инвестмэнт Лимитед компанийн нэр дээрх 20,800,000 ширхэг энгийн хувьцааг мөн Бодь Интернэшнл ХХК-д шилжүүлэх;
- Энэхүү компанийг татан буулгах болон хөрөнгө шилжүүлэхтэй холбоотойгоор Голомт банкны 2.57% хувьцаа эзэмшил өөрчлөгдөхөд шаардлагатай шийдвэр, зөвшөөрлийг авах үйл ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг Голомт банкны ТУЗ-д ирүүлсэн.

Энэхүү хүсэлтийг ТУЗ хүлээн авч ХЭ-ийн хурлаар шийдвэрлүүлэхээр өргөн барьж байна.

Хурлын дарга Г.Ганболд: Танилцуулгын дагуу батлах асуудал бол Голомт банкны Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай байна. Та бүхэнд шийдвэрийг уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл

Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг 62.1.15 дахь заалт, Голомт банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2.12 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 17-ны өдрийн ээлжит хурлын санал хураалт, Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. Хувьцаа эзэмшигч “Голомт Инвестмент Лимитэд” компанийг татан буулгах тухай уг компанийн эрх бүхий этгээдийн шийдвэр гарсантай холбогдуулан “Голомт Инвестмент Лимитэд” компанийн эзэмшиж буй 20,800,000 (хорин сая найман зуун мянган) ширхэг хувьцааг “Голомт Инвестмент Лимитэд” компанийн цорын ганц хувьцаа эзэмшигч болох “Бодь интернэшнл” ХХК-д шилжүүлэн олгож, хувьцаа эзэмшигч “Бодь интернэшнл” ХХК-ийн нийт эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээг 48,461,497 (дөчин найман сая дөрвөн зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун ерэн долоо) ширхэг болгож өөрчлөхийг зөвшөөрсүгэй.



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хурлын дарга Г.Ганболд: Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулах болон шийдвэрлүүлэх асуудлуудын танилцуулгууд хийгдэж дууслаа. Одоо танилцуулсан асуудлуудтай холбоотой асуулт асуух боломжоор хангая. Заалнаас асуулт асуух хувьцаа эзэмшигч нар гараа өргөнө үү.

Асуулт хариулт.

Хувьцаа эзэмшигч Оюунцацрал: Сая би буруу хараагүй бол шинээр нэмж хувьцаа гаргахад хуучин дээр нь нэрлэсэн ханш 250 төгрөг шинэ дээр нь нэрлэсэн үнэ 1000 гэж тавьсан байгааг тодруулъя. Нэмэгдүүлж байна уу, би буруу харсан уу?

ТУЗ-ийн НБД З.Солонго: Манай дүрэм дээр энгийн болон давуу эрхийн гээд хоёр төрлийн хувьцаа зарласан байгаа, энгийн хувьцааны нэрлэсэн үнэ нь 250 төгрөг хэвээрээ, зарласан хувьцааны нэрлэсэн үнэ нь 1000 төгрөг байгаа. Та үүнийг андуурсан байх.

Хувьцаа эзэмшигч Зоригтбаяр: Гурван асуулт байна. Нэг нь ТУЗ-ийн Даргаас асуумаар байна, нөгөө нь ТУЗ-ийн Хараат бус гишүүдээс асуух гэсэн юм.

Банкны хуульд өөрчлөлт ороод нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд хэмжээ 20% болж өөрчлөгдсөн байгаа. Анх IPO хийж байхад энэ хуулийн заалт 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гэж ойлгосон. Гэтэл харамсалтай нь энэ хуулийн хугацааг гурван жилээр сунгасан байна. Сунгасан 3 жилийн 1,5 жил нь өнгөрсөн байна. Үлдсэн 1,5 жилд энэ хуулийн заалт хэрэгжиж чадах уу гэдгийг ТУЗ-ийн даргаас асуумаар байна. Хэрэв та энэ хуулийн заалтыг хангаж ажиллаж чадахгүй бол ёс зүйн хариуцлага хүлээгээд ажлаа өгөх үү?

Монголбанкны Ерөнхийлөгчийг баталсан ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилох тухай журам дээр банкны ТУЗ-ийн хараат бус гишүүд жилд хоёр удаа тайлан тавих ёстой. Энэ тайлан нь журмын шаардлага хангахгүй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь олон улсад ажиллаж байсан банк санхүүгийн туршлагатай хүмүүс хэрнээ яагаад Монгол улсын хууль дүрэм журмыг хүндэтгэхгүй байна вэ?

Сүүлийн асуултаа хурлын даргаас асуучихъя. Банкны хувьцааны балансын үнэлгээ 1700 төгрөг байгаа гэж байна. Зах зээл дээрх ханш 1000 гарантай байна. Энэ тал дээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалаад банкнаас хадгаламж барьцаалсан зээл авч болдог шиг хувьцаа барьцаалсан зээл гэдэг бүтээгдэхүүн гаргаж болох уу?

Хурлын дарга Г.Ганболд: Мөнхцэцэг дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцоогүй. Хувьцаа барьцаалсан зээл гаргах тухай бид болон бусад банкууд судалдаг. Гэхдээ ямар хувьцааг барьцаалах вэ гэсэн асуудал гарна. Монголын хувьцааны зах зээл хөрөнгийн бирж бий болоод 1992-1993 оноос эхэлсэн ч гэсэн сүүлийн 5 жил идэвхтэй арилжаа явагдаж, банкууд нээлттэй компани болсноор нэмэгдсэн. Хувьцааны үнэ нь цагаар өөрчлөгддөг тул энэ бүтээгдэхүүнийг барьцаа болгоход төвөгтэй. Хадгаламж бол өөрийн гэсэн үнэтэй, хугацаатай байдаг учраас үнэ болон хугацаатай нь тохируулаад зээл гаргаж болдог. Монголын хөрөнгийн зах зээл дэх хувьцаан маш их савалгаатай тогтвортой бус байгаа.

Гүйцэтгэх захирал А.Одонбаатар: Банкны тухай хуулийн хязгаарлалтын 20 хувийн шалгуурын хувьд банкны хувьцааг зарах тал дээр бид маш нээлттэй байдаг. Бид хувьцаа эзэмшигч нартаа нээлттэй ил тод байх зарчмын хүрээнд та бүхэнд хэлэхэд энэ шалгуурыг хангаж ажиллах асуудал маш хэцүү байгаа. Өнөөдрийн Монгол улсын нийгэм эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчныг харахад тийм ч таатай бус байна. Гэхдээ манай банкны хувьд 2024 онд олон улсын зах зээлд бонд гаргасан бэ гэхээр олон улсын хөрөнгө оруулагчид банкаа таниулах гэж гаргасан юм. Бидэнд хувьцааны төвлөрөлөө бууруулахад нэгт олон нийтэд хувь эзэмшлээ санал болгох, хоёрт олон улсын зах зээлд гарах ийм л хоёр боломж байна. Бид одоогоор Нью Йорк, Лондон зэрэг хөрөнгийн биржүүдэд хувьцаагаа гаргах боломжуудыг судалж байна. Хувьцаа барьцаалсан зээлийн тухайд бид нээлттэй хандаж, боломжуудыг судалдаг. Харин Голомт банк нь өөрийнхөө хувьцааг барьцаалаад зээл олгох нь Банкны тухай хуулийн 36.12 дахь заалтын дагуу банкны хувьцааг барьцаалах, Монголбанкны зөвшөөрөлгүйгээр буцаан худалдахыг хориглосон байгаа. Манай хувьцааны үнийн хувьд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад чухалд тооцогддог book value (балансын үнэ) болон PE ratio үзүүлэлтүүдийг харахад манай банкны хамгийн хямд бөгөөд ашигтай хувьцаа гэж



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

үнэлэгдэж байгаа. ТУЗ-ийн Хараат бус гишүүний тайлангтай холбоотой асуултыг ТУЗ-ийн Хараат бус гишүүдтэй холбогдож байгаа ТУЗ-ийн НБД хариулана.

ТУЗ-ийн НБД З.Солонго: ТУЗ-ийн хараат бус гишүүд Монголбанкны журмын дагуу тайлагнах илүү өндөр хариуцлага үүргүүд хүлээдэг. Үүний хүрээнд улирал бүр өөрсдийн оролцсон хурал болгон, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр бүрт ямар санал өгсөн, ер нь Голомт банкны үйл ажиллагааг юу гэж дүгнэж байгааг хамруулан маш дэлгэрэнгүй тайлагнадаг байгаа. Энэ тайланг улирал бүр Монголбанкны хяналт шалгалтын хэлтэст хүргүүлж, банкны вэбсайтад нийтэлдэг. Мөн үүнээс гадна банк чухал хэлцэл хийсэн тохиолдолд Монголбанкинд 14 хоногийн дотор тайлагнаж мэдээлдэг. Энэ бүх хууль журмын шаардлагуудаа бүрэн хангаж ажилладаг. Тайлангийн агуулгад эрсдэлийн удирдлагын хорооны дагуу зээлийн хорооны шийдвэрийг хянадаг тул харилцагчийн зээл, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл асуудлууд туссан байдаг. Энэ бүрэн тайлан нь Монголбанкинд цаг тухайд нь хүргэдэг. Гэхдээ олон нийтэд мэдээлэхдээ харилцагчийн нууцыг хадгалах, хувь хүний мэдээллийг нууцлах үүднээс, холбоотой хууль журмын дагуу тодорхой хэсгийг нь хасаж оруулдаг.

Хурлын дарга Г.Ганболд: Өөр асуулт байхгүй бол ийнхүү бид Тооллогын комисс-д ажлаа хийж санал хураалтын үр дүнг эцэслэх боломж олгоё. Одоо 25-30 санал аа өгч дуусах боломжийг хангаад 12 цагт санал авах системийг зогсоож, Тооллогын комисс үр дүнг танилцуулах болно. Санал хураалтад оролцох боломжоор ханган шаардлагатай бол харилцагчийн зөвлөх охидууд төхөөрөмжтэй туслахаар зогсож байгаа, тиймээс тусалцаа шаардлагатай бол хандаад туслуулаарай. Мөн цаасаар санал өгөх хүсэлтэй бол хэлээд тусалцаа авах боломжтой байгаа. Завсарлаж байгаа тул кофе цай мөн бэлдсэн байгаа тул та бүхэн чөлөөтэй үйлчлүүлээрэй.

Хурлын дарга Г.Ганболд: Одоо та бүхэнд Тооллогын комиссийн дарга санал хураалтын нэгдсэн үр дүнг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Б.Хишигжаргал: Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комисс санал хураалтын нэгдсэн үр дүнг гаргаж дууслаа. Та бүхэнд санал хураалтын үр дүнг нэгдсэн байдлаар асуудал бүрээр танилцуулъя.

- 1. Голомт банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах**
Нийт саналын тоо: 734,355,468
Зөвшөөрсөн: 730,614,831
Татгалзсан: 112,819
Түдгэлзсэн: 3,627,818
- 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах**
Нийт саналын тоо: 734,355,468
Зөвшөөрсөн: 730,605,890
Татгалзсан: 121,779
Түдгэлзсэн: 3,627,799
- 3. Банкны зарласан энгийн хувьцааны тоо ширхэгийг нэмэгдүүлэх, нэмж гаргах энгийн хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн тухай**
Нийт саналын тоо: 734,355,468
Зөвшөөрсөн: 730,457,945
Татгалзсан: 447,579
Түдгэлзсэн: 3,449,944
- 4. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх тухай**
Нийт саналын тоо: 734,355,468



ГОЛОМТ БАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Зөвшөөрсөн: 730,460,273

Татгалзсан: 439,909

Түдгэлзсэн: 3,455,286

5. Голомт банкны дүрэм өөрчлөн батлах тухай

Нийт саналын тоо: 734,355,468

Зөвшөөрсөн: 730,474,146

Татгалзсан: 427,022

Түдгэлзсэн: 3,454,300

6. Голомт банкны ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Ч.Мөнхцэцэг 728,806,471

Д.Мөнхтөр 725,716,319

Ж.Үнэнбат 723,148,062

О.Ганжолоо 722,500,854

Александр Пикер 723,168,124

Жэймс Б. Двайер 721,956,792

Ханс Холзхакер 721,766,700

Роберт В.Ван Свитен 722,451,294

Ронил Сүжан 722,375,435

Нийт санал: 6,609,199,212

Түдгэлзсэн саналын тоо: 97,309,161


Хурлын дарга Г.Ганболд: Голомт банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа болон бусад асуудлуудыг хэлэлцсэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал баталсан асуудлуудаа амжилттай хэлэлцээд үүгээр өндөрлөж байна. Хурлаас гаргасан асуудал бүрийн саналыг хувьчилж баталлаа. Ийнхүү өнөөдрийн хуралд оролцсон эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд талархсанаа илэрхийлье.

Хурал 12:12 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БАТАЛСАН:

Хурлын Дарга

Голомт банкны Ерөнхийлөгч



Г. Ганболд

ТЭМДЭГЛЭЛ ХЯНАЖ БЭЛТГЭСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

Нарийн бичгийн дарга



З. Солонго